

АСЕАН-Ы ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИНТЕГРАЦИ: ЗАРИМ ТУРШЛАГА, СУРГАМЖ

*С.Дашцэвэл**

Зүүн Өмнөд Азийн бүс нутаг бол олон улсын зам харилцааны уулзвар, өрнө, дорныг далайн замаар холбосон зам тээврийн чухал гүүр газар билээ. Тийм ч учраас энэ бүс нутагт ХҮИ зуунаас эхлэн худалдааны томоохон боомтууд бий болжээ. 1967 онд Зүүн Өмнөд Азийн Тайланд, Сингапур, Малайз, Индонез, Филиппин зэрэг орнууд АСЕАН хэмээх бүсийн улс төр эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага байгуулсан билээ. Эдүгээ АСЕАН Зүүн Өмнөд Азийн бүх улсуудыг /10 орон/ хамарсан эдийн засаг, улс төрийн хамтын ажиллагааны нэгэн чухал байгууллага болов.

500 сая хүн амтай энэ бүс нутаг дулаан орны хөдөө аж ахуйн болон эрдэс баялгийн их нөөцтэй ажиллах хүч, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын томоохон зах зээл билээ. Сүүлийн жилүүдэд АСЕАН-ы орнуудын удирдлага үндэсний, бүс нутгийн эдийн засгийн чадавхийг улам илүү нээж эрчимтэй хөгжихийн тулд өөр хоорондын болон олон улсын эдийн засгийн интеграцийг нэн чухалчлах боллоо.

1992 оноос өмнө АСЕАН-ы эдийн засгийн хамтын ажиллагаа тийм ч үр дүнтэй байсангүй. Гагцхүү 1990-ээд оны эхнээс бүр тодруулбал АСЕАН-ы худалдааны чөлөөт бүс байгуулагдсаны дараа хөгжлийн шинэ үед оров. Эдийн засгийн интеграци нь худалдаа, хөрөнгө оруулалт, мөнгө санхүү, хөдөлмөр, үйлчилгээний харилцаагаар дамжин хэрэгждэг билээ.

АСЕАН-ы интеграцийн гол зорилго нь бүс нутгийн орнуудын эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх явдал юм.

АСЕАН-ы эдийн засгийн интеграцид хэд хэдэн зарчим үйлчилдэг. Тухайлбал, АСЕАН-ы гишүүн орон хамтын ажиллагааны санал санаачлага гаргаж түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулах эрхтэй. Тэрхүү гаргасан санал, боловсруулсан төсөл ба хөтөлбөрийг бусад бүх гишүүн орнууд дэмжсэн саналаа өгч албан ёсоор баталгаажуулна. Хэрвээ аль нэг гишүүн орон татгалзвал АСЕАН-ы төсөл ба хөтөлбөр болж чаддаггүй.

АСЕАН-ы хамтын ажиллагааны албан ёсны төсөлд 3-аас дээш гишүүн орон оролцох ёстой. Өөрөөр хэлбэл, бүх гишүүн орнууд заавал

* С.Дашцэвэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

оролцох албагүй. АСЕАН-ы хамтын ажиллагааны хөтөлбөр тус бүрийг аль нэг орон хариуцан авдаг. Жишээ нь: АСЕАН ба Дэлхийн худалдааны байгууллагын хамтын ажиллагааны хөтөлбөрийг Сингапур улс хариуцдаг. АСЕАН ба Европын Холбооны хамтын ажиллагааны хөтөлбөрийг Тайланд, АСЕАН-ы хөрөнгө оруулалттай холбоотой төслийг Малайз улс тус тус хариуцдаг. Тэгэхдээ тухайн хөтөлбөрийг хариуцсан орон бусдаас давуу эрхийг эдлэх ёсгүй.

АСЕАН-ы гишүүн орнууд эдийн засаг, зах зээлийн салбарт нягт хамтран ажиллахын зэрэгцээ ширүүн өрсөлдөөн дунд оршин тогтнодог. Энэ нь зах зээлийн ертөнц дэх хамтын ажиллагааны энгийн зүй тогтол билээ. Ялангуяа АСЕАН-ы гишүүн орнуудын ихэнх нь адил төрлийн экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, хөрөнгө оруулалтын эрэлт шаардлага өндөр гэх мэт онцлог нь өрсөлдөөнийг нэмэгдүүлэх үндэс шалтгаан болж байна. Гэхдээ АСЕАН-ы гишүүн орнуудын хамтын ажиллагааны хэлэлцээ, мэтгэлцээн болон зах зээлийн өрсөлдөөнд гол барьдаг зарчим нь үндэсний эрх ашгийг гол болгохын зэрэгцээ аливаа хамтын ажиллагааны асуудалд уян хатан хандаж оновчтой зөв буулт хийх, тэр нь эргээд өөр асуудалд ашигтай хариу буулт болж солигдох боломжийг эрэлхийлдэг. Өөр нэг гол зарчим нь гишүүн орнууд үндэсний ашиг сонирхлоо хамгаалахын хамт АСЕАН-ы эв нэгдлийг сахиж хамтын хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах явдал гэж үздэг.

1. АСЕАН-ы чөлөөт худалдаа буюу худалдааны салбар дахь интеграци

Өнгөрсөн 30 гаруй жилийн турш АСЕАН-ы хамтын ажиллагааны хамгийн чухал салбарын нэг нь худалдааны салбар байлаа. АСЕАН-ы худалдааны бодлого нь 2 талын худалдааг хөгжүүлэхийн зэрэгцээ худалдааны чөлөөт зах зээл рүү чиглэж ирсэн юм. Тухайлбал, 1977 онд АСЕАН-ы зарим гишүүн орнуудын хооронд худалдааны давуу эрхийн хэлэлцээр байгуулагдсан нь бүсийн худалдааг чөлөөт зах зээлд аажмаар шилжүүлэх анхны арга хэмжээ байлаа.

Гишүүн орнууд энэхүү гэрээнд нэгдэхдээ өөр өөрийн боломж бололцоогоор худалдааг алхам алхмаар чөлөөлөх механизмыг хэрэгжүүлэв. Эхний үед гишүүн орнууд худалдааны татварыг бууруулах барааныхаа нэр төрлийг сайн дурын үндсэн дээр тодорхойлж байсан бол 1980-аад оноос худалдааг чөлөөлөх явц улам түргэсч АСЕАН-ы гишүүн бүх улсуудыг хамарсан гааль татварын нэгдсэн тарифын бодлого руу тууштай чиглэв.

1986 онд гишүүн 6 орны 12 мянга гаруй нэр төрлийн бараа худалдааны давуу эрхийн гэрээнд хамрагдав. АСЕАН-ы орнуудын экспортын хэмжээ аажмаар өсч гадаад худалдааны тэнцэл 1980-аад онд эерэг үзүүлэлттэй болжээ.

1980-аад оны эцсээр АСЕАН-ы орнууд чөлөөт худалдааны бүс байгуулах асуудлыг нухацтай авч хэлэлцээд 1992 онд АСЕАН-ы чөлөөт худалдааны бүс буюу AFTA /Asian Free Trade Area/-г байгуулсан юм билээ.

АСЕАН-ы чөлөөт худалдааны бүс байгуулагдсаны гол зорилго нь худалдаа, хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгох явдал байлаа. Энэ нь бүс нутагт орчин үеийн үйлдвэрлэл хөгжиж шинэ технологи нэвтэрч дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн нэмэгдэх үүд хаалгыг нээсэн чухал арга хэмжээ юм. АСЕАН-ы орнууд худалдааны татварыг бууруулах *сонголт бүхий нэгдсэн тарифын гэрээ*-СЕРТ /Common Effective Preferential on Tariff/-гээр дамжуулан AFTA-г алхам алхмаар хэрэгжүүлж эхлээд байна.¹

АСЕАН-ы хуучин гишүүн орнууд /АСЕАН-6/ өөр хоорондоо худалдааны гаалийн татварыг 1993-2003 онд 0-5% болтол бууруулахаар тохиролцсон юм.² Ингэхдээ гишүүн орнууд үндэсний эдийн засгийн нөхцөл боломждоо түшиглэн тарифийн гэрээнд хамруулах барааныхаа нэр төрлийг бие даан сонгож байна. Худалдааны татварыг бууруулахад чиглэсэн энэхүү гэрээг хэрэгжүүлэхийн тулд улс орон бүхэн бараа бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг дараах маягаар ангилж байна. Үүнд:

- 1/ Татварыг бууруулах бүтээгдэхүүн-IL /Inclusion List/
- 2/ Тодорхой хугацаанд татвар бууруулахгүй бүтээгдэхүүн-TEL /Temporary Exclusion List/
- 3/ Татварыг ер бууруулахгүй бүтээгдэхүүн-GEL /General Exclusion List/

4/ Хөдөө аж ахуйн гаралтай боловсруулаагүй түүхий эд буюу эмзэг мэдрэмж бүхий бараа SL /Sensitive List/.³

Үүний дотор IL ангилалын бүтээгдэхүүнийг яаралтай бууруулах, яарамгүй бууруулах гэж мөн 2 хувааж тус хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлж байна.

Яаралтай бууруулах бараанд худалдааны татвар нь 20-иос доошгүй хувь байгаа ургамлын тос, цемент, зарим химийн бүтээгдэхүүн, эм тариа, төрөл бүрийн бордоо, хуванцар эдлэл, каучукийн гаралтай бүтээгдэхүүн, төрөл бүрийн арьс ширэн эдлэл, нэхмэл, сүлжмэл

бүтээгдэхүүн, ваар, шил шаазан эдлэл, үнэт чулуу, гоёл чимэглэлийн зүйл, электрон техник, мод, хулсан эдлэл зэрэг өргөн хэрэглээний 20-иод төрлийн барааг хамруулжээ.

1. Импортын татварыг яарамгүй бууруулах бараанд 20-иос дээш татвартай бараа голлож байгаа бөгөөд түүнийг 2 үе шатаар бууруулах юм. Үүнд эхний шатанд /8 жилийн хугацаанд 20-иос доош хувь болгох/, дараагийн шатанд /7 жилийн хугацаанд түүнийг 5% хүртэл бууруулах гэх мэт/ энэхүү тохиролцоонд АСЕАН-ы гишүүн орнууд 1992 онд хүрч 1993 оноос эхлэн хэрэгжүүлж эхлэв.

АСЕАН-6 буюу хуучин гишүүн /Тайланд, Сингапур, Малайз, Индонези, Филиппин, Бруней/ орнууд уг хөтөлбөрийг 2003 онд хэрэгжүүлж дуусах бөгөөд АСЕАН-д хожим элссэн шинэ гишүүд тухайлбал Вьетнам улс 2006 онд, Лаос, Мьянмар, Кампучи улс 2015 онд тус тус хэрэгжүүлж дуусах юм.

2. Худалдааг чөлөөлөх энэхүү үйл явц гишүүн орнуудын эдийн засгийн чадамж боломжтой шууд холбоотой учраас нэг хэсэг барааны импортын татварыг түр хугацаагаар бууруулахгүй байх, зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортын татварыг хэзээ ч бууруулахгүй гэх мэт бодлого баримталдаг.

Татвар бууруулахгүй бүтээгдэхүүний жагсаалтад гол нь үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх бүтээгдэхүүн, нийгмийн ёс зүй, хүнсний эрүүл мэндэд харш бүтээгдэхүүн, мөн зарим амьтан, ургамал, урлаг, түүх соёлын дурсгалтай холбогдох эд юмс хамрагдаж байна.

АСЕАН-ы орнууд худалдааны нэгдсэн тарифдаа ХАА-н гаралтай боловсруулаагүй түүхий эдийг үндсэнд нь хамруулахгүй байгаа бөгөөд зөвхөн зах зээлийн эрэлтийн болзол хангасан мах махан бүтээгдэхүүн, загас, далайн гаралтай түүхий эд, сүү сүүн бүтээгдэхүүн, кофе цай, үр тариа зэрэг цөөн төрлийн барааг хамруулж байна. ХАА-н гаралтай боловсруулаагүй түүхий эдийг аль болохоор анхан шатны буюу гүнзгийрүүлэн боловсруулж зах зээлд гаргах нь эдийн засгийн үр ашигтай тул улс орон бүхэн энэ чиглэлээр хөрөнгө оруулалтыг сонирхож шинэ техник, технологи нэвтрүүлж зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах бодлого баримталж байна.

**АСЕАН-ы орнууд худалдааны сонголт бүхий нэгдсэн
тариф /СЕРТ/-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа байдал**

Улсууд	Импортын татварыг хөнгөлсөн бараа	Түр зуур хөнгөлөхгүй бараа	Хөнгөлөхгүй бараа	ХАА-н түүхий эд	Нийт дүн
Бруней	6.276	0	202	14	6.492
Индонези	7.192	21	68	4	7.285
Малайз	9.989	218	53	83	10.343
Филлиппин	5.621	6	16	50	5.693
Сингапур	5.859	0	0	0	5.859
Тайланд	9.104	0	0	7	9.111
АСЕАН-6	44.041	245	339	158	44.783
Хувь	98.34	0.55	0.76	0.53	100.00
Кампучи	3.115	3.523	134	50	6.822
Лаос	1.673	1.716	74	88	3.551
Мьянмар /Бирм/	2.984	2.419	48	21	5.472
Вьетнам	4.233	822	139	51	5.245
Шинэ гишүүн орнуудын нэгдсэн дүн	12.005	8.480	395	210	21.090
Хувь	56.92	40.21	1.87	1.00	100
Нийт АСЕАН	56.046	8.725	734	368	65.873
Хувь	85.08	13.25	1.11	0.56	100.00

АСЕАН-ы нарийн бичгийн дарга нарын
газрын эх сурвалж, 2001 оны байдлаар

2003 он гэхэд АСЕАН-ы гишүүн 6 орон СЕРТ хөтөлбөрийг үндсэндээ хугацаанд нь хэрэгжүүлээд байна. Харин АСЕАН-д шинээр нэгдсэн орнууд дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зохистой аргыг сүвэгчлэх, үндэсний бүтээгдэхүүнийхээ өрсөлдөх чадварыг аль болох түргэн нэмэгдүүлэх зорилгоор арай хожуу хэрэгжүүлж дуусах юм.⁴

АСЕАН-ы орнуудын туршлагаас харвал бүс нутгийн орнууд эхлээд 2 талын худалдааны нэгдсэн тариф мөрдөж, худалдааны гааль татварын бодлогоо харилцан уялдуулж зарим хөнгөлөлтийг бие биендээ

олгожээ. Дараа нь бүс нутгийн орнууд олон талт хамтын ажиллагаанд нэгдэж Худалдааны чөлөөт бүс /FTA/-ийг бий болгож гааль татварын элдэв хаалт /лиценз, квот гэх мэт/-ыг арилгаж бүс нутгийн гишүүн орнуудын дунд чөлөөт өрсөлдөөний зах зээлийг бий болгож байна. Энэ нь АСЕАН-ы орнууд экспортыг баримжаалсан үйлдвэрлэлийг хөгжүүлж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн АПЕК, WTO зэрэг олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны үйл явцад бие даан үр ашигтай оролцох чухал бэлтгэл болж өгч байгаа юм.

2. АСЕАН-ы аж үйлдвэрийн интеграци ба AICO

АСЕАН-ы орнуудын худалдааны чөлөөт бүс АФТА бий болсон явдал гадаад хөрөнгө оруулалтыг татах чухал нөхцлийг бүрдүүлсэн хэмээн дээр тэмдэглэсэн. АСЕАН-ы орнуудад хөрөнгө оруулалт өсөхийн хамт үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийн шинэ үе эхлэв. Энэ нь АСЕАН-ы орнуудад аж үйлдвэрийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах боломж олгов.

Урьд нь аж үйлдвэрийн салбарт хамтын ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр гэх мэтийг хэрэгжүүлж байсан бөгөөд түүнээс зарчмын ялгаатай AICO (Asian Industrial Cooperation) хэмээх аж үйлдвэрийн хамтын ажиллагааны механизм 1996 онд бий боллоо. AICO нь АСЕАН-ы орнуудын аж үйлдвэрийн түүний дотор жижиг, дунд үйлдвэрийн хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжээд зогсохгүй АСЕАН-ы дотоодын болон гадаад түншүүдийн хөрөнгө оруулалтыг АСЕАН-ы үйлдвэрлэлийн салбарт нэгтгэх, гишүүн орнуудын хөрөнгө чөлөөтэй шилжих илүү таатай нөхцөл бүрдүүлэх зорилготой механизм юм. AICO-г бас АСЕАН-ы орнуудын аж үйлдвэрийн хамтын ажиллагааны байгууллага буюу бүтэц /arregement/ ч гэж ойлгож болно. AICO нь үйлдвэрийн хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах идэвхжүүлэхийн тулд тусгай нөхцөл хангасан үйлдвэр, корпорациудыг өөртөө нэгтгэн тэдний үйл ажиллагааг зангидан залуурдах үүрэгтэй юм. AICO-ын үйл ажиллагаа нь дараах үндсэн асуудалд чиглэгдэж буй. Үүнд:

- 1/ Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үүргийг өндөр болгох;
- 2/ АСЕАН-ы доторх аж үйлдвэрийн бүтээгдэхүүний худалдааг дэмжих;
- 3/ Зарим төрлийн үйлдвэрлэлийг онцлон анхаарч нэгдсэн бодлогын дагуу шийдвэр гарган хэрэгжүүлэх;
- 4/ Шинэ тутам элссэн гишүүн орнуудад техник технологийн дэмжлэг үзүүлэх гэх мэт.⁵

AICO-д нэгдсэн АСЕАН-ы хамтарсан үйлдвэр, корпорациудын бүтээгдэхүүн гааль, татварын давуу эрх эдэлнэ. Зөвхөн эцсийн бүтээгдэхүүн төдийгүй AICO-ын хамтын үйлдвэрт очих хагас

боловсруулсан бүтээгдэхүүн ч үүнд хамаарна. Өөрөөр хэлбэл дээр дурьдсан бүх бүтээгдэхүүний импортын татвар СЕРТ-ийн гэрээний дагуу 0-5%-ийн дотор байна. Түүнээс илүү татвар оногдуулахгүй гэсэн үг. /АСЕАН-ы орнуудын импортын татвар нэгдсэн тарифт ороогүй бол 20-40% байгаа/

AICO-д оролцохыг хүссэн үйлдвэр, корпорациуд дараах нөхцлийг хангасан байх ёстой ажээ. Үүнд:

1/ АСЕАН-ы аль нэг оронд үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа мөн тэндээ явуулдаг;

2/ Төрийн мэдлийн хувьцаа дор хаяж 30% байх;

3/ Мэргэжлийн ажиллах хүч харилцан нийлүүлдэг туслах чанарын үйлдвэрүүдийн хамтын дэмжлэг байх гэх мэт.

Мөн түүнчлэн төрийн мэдлийн хувьцаа 30%-д хүрэхгүй байгаа тохиолдолд:

1/ Үлэмжхэн нэмүү өртөг бий болгох шинэ бүтээгдэхүүн, эсвэл үйлдвэрлэлийн системд ашиглагдахуйц шинэ материал тоног төхөөрөмж үйлдвэрлэх;

2/ AICO-д жижиг, дунд үйлдвэрүүдийг нэгтгэх буюу тэдний оролцох сонирхлыг татсан байх;

3/ Экспортын үүргээ сайтар хангасан буюу тэргүүлэх салбаруудад хөрөнгө оруулсан байх;

4/ АСЕАН-ы 30%-иас доошгүй хөрөнгө оруулалттай байх г.м нөхцлүүдийг хангасан байвал AICO-д оролцох боломжтой ажээ.⁶

АСЕАН-ы орнууд хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогоор зохицуулж байна. Гол агуулга нь гишүүн орнуудын хөрөнгө өөр хоорондоо чөлөөтэй шилжих боломж олгож байгаагаас гадна гадаадын хөрөнгө АСЕАН-ы бүсэд урсан орох таатай нөхцлийг бүрдүүлэхэд АСЕАН-ы бодлого чиглэгдэж байна. Үүний тул гишүүн орнууд хөрөнгө оруулалтын нэгдсэн орчинг юуны өмнө бүрдүүлж хөрөнгө оруулалтын хуулиндаа засвар, өөрчлөлт хийж хөнгөлөлтийн нөхцлүүдийг нэмэгдүүлж өгчээ.

АСЕАН-ы гишүүн орнууд АСЕАН-ы хөрөнгө оруулалтын бүс AIA /Asian Investment Area/-ын тухай гэрээ 1998 онд байгуулав. Энэ гэрээг хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг гишүүн орнууд 2 жил тутам тодотгож үйл ажиллагааны төлөвлөгөө болгон хэрэгжүүлж байна.

3. Хүнс, хөдөө аж ахуй болон бусад салбар дахь интеграци

АСЕАН-ы хүрээнд хөдөө аж ахуйн нэгдсэн бодлого боловсруулж түүнийгээ амжилттай хэрэгжүүлж байна. Бодлогын зорилго нь ХАА-г тогтвортой хөгжүүлэх хөтөлбөрөөр дамжуулан амьжиргааны түвшин ба чанарыг дээшлүүлэхэд чиглэж ирлээ. Бүс нутгийн хэмжээгээр аюулгүй

хүнсний хөтөлбөр хэрэгжүүлж хүнсний үйлдвэрлэл хуваарилалтын сүлжээг боловсронгуй болгож байна. ХАА-н түүхий эдийг боловсруулах орчин үеийн техник технологи бүхий үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих замаар бүс нутгаа аюулгүй цэвэр хүнсээр хангаад зогсохгүй дэлхийн зах зээлд өрсөлдөж энэ чиглэлээр Азид төдийгүй дэлхийн тэргүүлэх бүс нутаг болохоор шамдаж байна.

Олон улсын валютын сангийн үзэж буйгаар үйлчилгээний салбарт олон хэлбэрийн үйл ажиллагаа хамаарна. Үүнд, мэдээлэл холбоо, зам тээвэр, радио телевиз, боловсрол сургалт, эрүүлийг хамгаалах, даатгал, аялал жуулчлал гэх мэт.

Сүүлийн жилүүдэд үйлчилгээний салбар аливаа улсын эдийн засагт чухал суурь эзэлж үндэсний орлогын үлэмж хувийг эзлэх боллоо. Цаашдаа энэ хандлага улам өсөх төлөвтэй ажээ. Үүний зэрэгцээ дэлхий дахинд аялал жуулчлалын өрсөлдөөн улам өсч байна. АСЕАН-ы гишүүн орнууд энэ үйл ажиллагаанд идэвхитэй татагдан оров.

1995 онд АСЕАН-ы орнууд үйлчилгээний салбарын хамтын ажиллагааны гэрээнд анх гарын үсэг зурсан билээ. Энэ үеэс эхлэн үйлчилгээний салбарт олон төрлийн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлж эхлээд байна. Энэ нь бүхэлдээ үйлчилгээний бизнесийг үр ашигтай хөгжүүлэхэд чиглэгджээ.

АСЕАН-ы орнуудад дээрх төрөл бүрийн үйлчилгээний салбараар мэргэжил эзэмшигчдийн мэргэжлийн түвшин туршлага болон ажиллах эрхийг харилцан хүлээн зөвшөөрч эхлэв. Энэ нь АСЕАН-ы орнуудын хөдөлмөрийн урсгалыг чөлөөлөхөд түлхэц болж байна.

Авто зам, далайн зам, агаарын замыг оролцуулсан зам тээврийн үйлчилгээг уялдуулан зохицуулж хэд хэдэн хамтарсан томоохон төсөл хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ АСЕАН-ы мэдээллийн дэд бүтцийг бий болгох ажлыг орчин үеийн электрон техникийн хувьсалтай уялдуулж байна. Үүнд бүс нутгийн мэдээллийн сүлжээг олон улсын мэдээллийн сүлжээтэй холбож хөгжүүлэх бүх талын нөхцөл бололцоог бий болгоод байна.

АСЕАН-ы орнууд эрчим хүчний интеграцийн үндэс суурийг бий болгох хөтөлбөрт гарын үсэг зурсан. Үүнд гишүүн орон тус бүрийн эрчим хүчний эх сурвалжийг хамаалах, үр ашигтай хэрэглэх талаар хамтран ажиллаж түүний үндсэн дээр АСЕАН-ы хүрээний бүх эрчим хүчний нөөцийг зүй зохистой нээн ашиглах хамтарсан тогтолцоог бүрэлдүүлэх ажлыг хэрэгжүүлж байна.

Товчоор хэлбэл, АСЕАН-ы орнууд АФТА, AICO, AIA зэрэг механизмууд бий болгож худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын салбарт хамтын ажиллагааг хүчтэй болгож байгаа нь АСЕАН-ы эдийн засгийн интеграцийг тууштай хөгжүүлэх чухал алхам

болж байна.

1977 оноос АСЕАН-ы гишүүн орнууд ам.долларыг тооцооны гол хэрэгсэл болгохоор сонгосон билээ. Төлбөрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тодорхой хэмжээний дундын санг бүрдүүлсэн байна. Гишүүн орон бүр 40 сая ам.доллараар санг бүрдүүлж зээлийн дээд хэмжээг 200 саяар тогтоосон. 1990-ээд оны санхүүгийн хямралаас сургамж авч бүс нутгийн мөнгөний нэгдсэн систем бий болгох асуудлыг хөндөх болов.⁷

АСЕАН-ы гишүүн орнууд банк, санхүү, бүртгэл тооцоо, даатгал, татварын талаар үйл ажиллагаагаа уялдуулж байгаа нь бүсийн худалдаа, хөрөнгө оруулалт, хамтын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж байна. Төв банкуудын хооронд хамтын ажиллагаа амжилттай хөгжиж гүйлгээг хөнгөн шуурхай болгосноос гадна мөнгөний нэгдсэн системд орох асуудлыг судалж эхлээд байна.

4. АСЕАН-ы орнуудын эдийн засгийн дэд бүсүүд

1980-аад оны эцэс, 1990-ээд оны эхээр АСЕАН-ы орнууд эдийн засгийн хамтын ажиллагааны дэд бүсүүд байгуулах ажлыг эхлэв. Эдүгээ АСЕАН-ы орнуудын хүрээнд эдийн засгийн хамтын ажиллагааны 4 дэд бүс үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

АСЕАН-ы өмнөд хэсгийн эдийн засгийн гурвалжин. 1989 онд байгуулагдсан. Сингапур, Малайзын өмнөд хэсэг дэх Жохо район, Индонезийн Риан арал үүнд хамаардаг. АСЕАН-ы умард эдийн засгийн гурвалжин. 1993 онд байгуулагдсан. Энэ гурвалжинд Тайландын өмнөд 5 муж, Малайзын умард мужууд, мөн Индонезийн Суматра арал багтана. АСЕАН-ы дорнод эдийн засгийн гурвалжин. 1994 онд байгуулагдсан. Индонезийн Калимантан арлын зүүн баруун хэсэг, Сулавеси арлын умард хэсэг, Филиппиний зарим арал, Брунейн газар нутаг энэ гурвалжинд багтдаг.⁸

Эдгээр гурвалжингууд нь эдийн засгийн хамтын ажиллагааны тусгай хөтөлбөр төслүүдийг дэд бүсийн онцлог болон давуу талд түшиглэн хэрэгжүүлж байна. Тэдгээрийн дотроос эдийн засгийн өмнөд гурвалжин нь бусдаас илүү үр ашигтай ажилладаг. Учир нь уг гурвалжингийн гол цөм болсон Сингапурын эдийн засгийн нөлөө их байгаа бөгөөд Малайз, Индонезид Сингапурын хөрөнгө оруулалт урсан орох болсон учраас энэ гурвалжингийн эдийн засгийн өсөлт үлэмж нэмэгдэв.

Сингапур, Малайзын худалдааны 40% уг гурвалжингаар дамжин хийгдэж байна. Сингапур, Индонезийн худалдаа үлэмж нэмэгдэж уг гурвалжинд хамрагдах Индонезийн арлуудад аялал жуулчлал амжилттай хөгжиж байна.

Сүүлийн жилүүдэд АСЕАН-ы орнууд дэд бүсийн хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд олон чухал арга хэмжээ хэрэгжүүлж байгаагийн нэг нь Меконгийн сав газрын эдийн засгийн хөгжлийн асуудал юм. Меконгийн сав газрын хамтын ажиллагааны Хороо 1996 онд байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн билээ.

Меконгийн сав газрын хамтын ажиллагаанд Вьетнам, Лаос, Тайланд, Кампучи, Бирм, Малайз, Өмнөд Хятадын Юньнань муж хамрагдаж байна. Эхний шатанд хамтын ажиллагааны зарчим уг дэд бүсийг хөгжүүлэх үндсэн хөтөлбөрүүдийг батлав. Юуны өмнө тус дэд бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх, түүний дотор умраас өмнийг холбосон босоо тэнхлэгийн төмөр замын магистрал барьж байгуулах /Өмнөд Хятадын Куньмин хотоос Сингапур хүртэл/ хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэв.

Үүний зэрэгцээ тус дэд бүсийн ХАА, далайн АА, ойн АА, хүний нөөцийн хөгжлийн асуудлыг онцлон анхаарч холбогдох төслүүдийг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Тухайлбал:

1/ Бүс нутгийн ойн нөөцийг хамгаалж зохистой ашиглах мэдээллийн сүлжээний системийг бий болгох;

2/ Хүний нөөцийн судалгааг гаргаж мэргэжил эзэмшүүлэх төвүүдийг байгуулах;

3/ ХАА-г механикжуулах;

4/ Үр тариа /цагаан будаа/-ны эрдэм шинжилгээний төвүүдийг бий болгож шинэ техник технологи нэвтрүүлэх;

5/ Газрын доорхи усны нөөцийг ашиглах ажлыг нэмэгдүүлэх;

6/ Цэнгэг усны загас үржүүлэх;

7/ Далайн гаралтай түүхий эдийг боловсруулах технологийн түвшинг дээшлүүлэх;

8/ Хязгаар нутгуудад услалтын системийг нэвтрүүлэх;

9/ Меконг мөрний нөөцийг судлах гэх мэт олон төслийг хэрэгжүүлж эхэлжээ.⁹

Дэд бүсэд хамрагдаж буй орнуудын ихэнх нь АСЕАН-ы буурай хөгжилтэй орнууд учир АСЕАН-ы хөгжлийн түвшинг ойртуулахад уг хамтын ажиллагаа чухал нөлөө үзүүлэх юм. 2001 онд АСЕАН-ы сайд нарын хуралдаанаас бүс нутгийн орнуудын /АСЕАН-ы орнуудын/ хөгжлийн түвшинг ойртуулах талаар хэлэлцэж тодорхой шийдвэр гаргасан юм.

АСЕАН-ы гишүүн орнууд оюунлаг эдийн засгийг бий болгох, хүний нөөцийг хөгжүүлэх, мэдээлэл цахилгаан холбооны технологийг шинэчлэх, бүс нутгийн болон олон улсын эдийн засгийн интеграцид улам өргөн бөгөөд гүнзгий оролцох замаар гишүүн орнуудын хөгжлийн түвшинг ойртуулж болно гэж үзэх боллоо.

5. АФТА-д оролцож буй Вьетнамын зарим туршлага ба дүгнэлт 2000 оны сүүлчээр АСЕАН-ы болон Хятадын удирдлага Сингапурт уулзаж хоёр талын харилцааг өргөжүүлэх арга замын асуудал хэлэлцэв. Дараа жилийн эцсээр хоёр талын удирдлага Брунейд дахин уулзаж АСЕАН-Хятадын худалдааны чөлөөт бүс байгуулах хэтийн төлвийг батлав. Хоёр тал худалдааны чөлөөт бүсийг 2010 онд байгуулж эхлэх, хүлээгдэж буй хугацаанд бэлтгэл ажлыг хийхээр болжээ. Ийнхүү АСЕАН-Хятадын чөлөөт худалдааны бүс байгуулагдвал 2 тэрбум шахам хүн ам бүхий 2000 тэрбум ам.доллар ДНБ-тэй, 1230 тэрбум ам.доллартай тэнцэх худалдааны эргэлт бүхий дэлхийн хамгийн том чөлөөт худалдааны бүс бүрэлдэн тогтох юм. Нөгөө талаар АСЕАН-Хятадын чөлөөт бүс байгуулагдах аваас тэрхүү чөлөөт бүсийн хил хязгаар Монгол Улстай залгах болно.

Үүнээс үүдэн Монгол Улс АСЕАН-Хятадын худалдааны чөлөөт бүсэд нэгдэх бэлтгэлийг одооноос бодолцох шаардлага гарч байна. Тийм учраас АСЕАН-ы худалдааны чөлөөт бүс АФТА-д шинэ тутам оролцож байгаа Вьетнамын байдлыг сонирхоё.

Вьетнам бол бидний адил төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай орон байв. Тийм учраас эдийн засаг нь хаалттай, үйлдвэрлэл нь дотоод хэрэгцээгээ хангах, экспортоо орлоход үндсэндээ чиглэж байв. Гэтэл 1990-ээд оны дунд үеэс АСЕАН-ы худалдааны чөлөөт бүс АФТА-д оролцож эхэлсэн. Үүний үр дүнд зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц нь нэн түргэсч экспортын баримжаатай орчин үеийн аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлж эхлэв.

Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд зах зээлийн эдийн засгийн эрх зүйн орчинг бүрдүүлж эдийн засгийн удирдлагын механизмыг бүс нутгийн болон дэлхийн жишигтэй уялдуулан өөрчлөв. Төрийн удирдлагын аппаратыг цомхон чадварлаг болгох чиглэлд томоохон алхам хийв. Төрийн захиргааны шинэчлэл бүхэлдээ эдийн засгийн өсөлтийн таатай нөхцөл бүрдүүлэхэд чиглэгдэж байна.

Энэ бүхэнд АСЕАН-ын гишүүн орнууд тал бүрээр дэмжиж байна. Нөгөө талаар АСЕАН-ы нэгдсэн зах зээлд оролцох болсноор эдийн засгийн бүтэц, ялангуяа экспортын бүтээгдэхүүний бүтцийг яаралтай өөрчлөхөөс өөр аргагүйд хүргэв. Тухайлбал, Вьетнам улс АФТА-д элссэн анхны жил буюу 1996 онд экспортлосон бүтээгдэхүүний 18% нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, 48% нь ХАА-н болон далайн гаралтай хагас боловсруулсан бүтээгдэхүүн, 34% нь түлш эрчим хүч байна.

Экспортын бүтэц энэ маягаар үргэлжлэх аваас АСЕАН-ы чөлөөт зах зээлээс экспортын нэн бага ашиг олох дүр зурагтай ажээ. Иймд экспортод баримжаалсан аж үйлдвэр хөгжүүлэхийг бодит байдал шаардаж байгаа юм.

Тэгэхдээ аль болох өрсөлдөх чадвартай өөрөөр хэлбэл өөрийн өртөг хямд мөртлөө чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж АСЕАН-ы болон дэлхийн зах зээлд өрсөлдөх, үүний тул үйлдвэрлэлд орчин үеийн техник, технологи нэвтрүүлэхэд бүхий л анхаарлаа төвлөрүүлж эхлэв.

АFTA-д элссэнээр Вьетнамын бараа АСЕАН-ы зах зээлд нэвтрэх таатай боломж бүрдэж экспортын хэмжээ нь өссөөр байна. Тэр нь эргээд Вьетнамын аж үйлдвэрийн салбарын өсөлтөнд эерэгээр нөлөөлж эхэллээ.

Мөн АСЕАН-ы чөлөөт зах зээлд нэгдсэнээр гадаадын хөрөнгө оруулалтыг татах нэг нөхцөл бүрдэв. /Учир нь Вьетнамд хөрөнгө оруулна гэдэг нь АСЕАН-ы 10 орны нэгдсэн зах зээлд хөрөнгө оруулна гэсэн үг./

АСЕАН-ы гишүүн орнууд хоорондын хөдөлмөрийн шилжилт түргэсч хямд хөдөлмөрийн зах зээл рүү зарим салбарын хөрөнгө оруулалт урсав. Жишээ нь: Малайз, Сингапур, Тайландын оёдол, сүлжмэлийн чиглэлийн хөрөнгө оруулалт Вьетнам, Индонез, Филиппин руу шилжих болов. АFTA-д элссэнээр энэ мэт эерэг тал олон байвч буурай хөгжилтэй орнуудад тохиолддог нийтлэг хэд хэдэн бэрхшээл ажиглагддаг.

СЕРТ-ийн хөтөлбөрийн дагуу Вьетнам улс 2006 оны эцэс гэхэд IL болон TEL ангилалын бүх төрлийн барааны татварыг 0-5% бууруулсан байх ёстой. Харин 20-иос дээш татвартай IL ангилалын барааг эхлээд 20%-иас хэтрэхгүй татвартай болгож, дараа нь жил тутам татварыг бууруулсаар 2006 он гэхэд 0-5%-ийн татвартай болгох, 20%-иос доош татвартай барааг 2003 он гэхэд 0-5%-ийн татвартай болгох, TEL-ангилалын барааг эхний 5 жилд 1999-2003 онд IL ангилалд шилжүүлж, дараа нь татварыг 2-3 жил тутам хөнгөлөх, GEL ангилалын барааны татварыг 2004-2013 оны хооронд 0-5% болгох гэх мэт үүргийг хүлээж байна.

Үүнийг хэрэгжүүлэхдээ гол нь үндэсний үйлдвэрлэлээ дампууруулахгүй байх, улсын төсөвт хүндрэл учруулахгүй байхыг хичээж байна. 2006 он гэхэд Вьетнам улс АСЕАН-ы бараг үндсэн бүх барааны татварын хөнгөлөлтөд хамрагдах юм. Энэ үед АСЕАН-ы орнуудаас татварын хөнгөлөлтөд хамрагдсан бүх төрлийн бараа урсан орж ирэх бөгөөд дотоодын үйлдвэрлэл цохилтод орохгүйгээр хамгаалагдсан байх ёстой. Өөрөөр хэлбэл дотоодын үндсэн гол бүтээгдэхүүн импортын бараатай өрсөлдөхүйц чанартай бөгөөд хямд өртөгтэй болсон байх ёстой. Эс тэгвээс олон үйлдвэр аж ахуйн газар хаагдах аюул нөмөрнө.

Иймд Вьетнам улс зах зээлийн чөлөөт өрсөлдөөнд оролцох бэлтгэл ажлыг маш богино хугацаанд амжиж хийхээс аргагүйд хүрэв.

Үүнийг хийж эс чадвал үр дагавар нь нэн хүнд тусч Вьетнам улс бусдаасаа хоцорч хөл дээрээ босохын аргагүйд хүрнэ. Харин АФТА-д амласнаа хугацаанд нь хэрэгжүүлж чадвал бусадтай эн зэрэгцэн түргэн хөгжих үүд хаалгыг нээнэ гэсэн үг.

Энэ бүхнээс үзвэл аль нэг бүс нутгийн интеграцид оролцоно гэдэг нь харьцангуй буурай хөгжилтэй орнуудад хүндхэн сорилт авчирдаг хатуухан тоглоом гэдэг нь ойлгомжтой байна.

Алив бүсийн хамтын ажиллагаа буюу интеграцид нэгдэнэ гэдэг нь хамтран ажиллах, өрсөлдөх хоёр зэрэгцэхийн утга бөгөөд өрсөлдөөнд ялагдвал өөрөө унасан хүүхэд уйлдаггүйтэй адил тоглоом ажээ. Үндэсний давуу талаа түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг орчин үеийн түвшинд хөгжүүлэхгүйгээр интеграци дахь өрсөлдөөнд ялахгүй, бас эрх тэгш оролцогч байж чадахгүй, зөвхөн эдийн засгийн дагуул орон болж хоцрох тул үндэсний хэмжээний оюун ухаан, хүч чадлыг дайчилсан үндэсний стратеги бодлого үүнд нэн чухал ажээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. АФТА-СЕРТ-ийн гэрээг 1993 оны 1-р сарын 1-ээс хэрэгжүүлж эхэлсэн.
2. Lien ket ASEAN trong boi canh toan cau hoa / Даяаршлын орчин дахь АСЕАН-ы интеграци/ Hanoi. 2002, Tr.144
3. Quan he kinh te quoc te /Олон улсын эдийн засгийн харилцаа/ Hanoi, 2003.Tr.89
4. Мөн тэнд. 99-р тал.
5. Kinh te cac nuoc Dong Nam A: thuc trang va trien vong /Зүүн Өмнөд Азийн орнуудын эдийн засаг: Бодит байдал ба хэтийн төлөв/. Hanoi,2002.Tr.118-119.
6. Viet Nam-ASEAN: co hoi va thach thuc /Вьетнам-АСЕАН: Боломж ба сорилт/. Hanoi,1998.Tr.80.
7. Hoi nhap kinh te khu vuc cua mot so nuoc ASEAN /Бүс нутгийн эдийн засгийн интеграци:АСЕАН-ы зарим орны жишээн дээр/ Hanoi, 2002. Tr.83.
8. Lien ket ASEAN... Tr.186.
9. Мөн тэнд.189-р тал.